

*МИГ Даатгал ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2020 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн
А/20-540 тоот тушаалын хавсралт*

МӨНГӨ УГААХ, ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээдийн хувьд “МИГ Даатгал” ХХК (цаашид “Компани” гэх) нь мөнгө угаах, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх мөнгөн гүйлгээг хянах, тайлагнах, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, түдгэлзүүлэх, сэжигтэй гүйлгээний талаар холбогдох дээд байгууллагад мэдээлэх, энэ талаар компанийн удирдлага ажилтнуудын зүгээс хэрэгжүүлэх үүрэг, авах арга хэмжээ түүнтэй холбогдон гарах харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү үйл ажиллагаандаа Монгол банкны Ерөнхийлөгчийн 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн А/26 тоот тушаалаар батлагдсан “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ыг бүрэн дагаж мөрдөнө.
- 1.3 Энэхүү журамд дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - 1.3.1 “санхүүгийн мэдээллийн алба” гэж Монгол банкны санхүүгийн мэдээллийн албыг;
 - 1.3.2 “мэдээлэх үүрэгтэй этгээд” /МҮЭ/ гэж хууль Санхүүгийн зохицуулах хороонд харьяалагдах мэдээлэх үүрэгтэй этгээд гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.3-д заасан этгээдийг;
 - 1.3.3 “мөнгө угаах” гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг;
 - 1.3.4 “үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хориглосон цөмийн, химийн, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж,

технологи болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зорилгоор хоёрдмол зориулалттай бараа, бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах, тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах, худалдах, худалдан авах, ашиглах аливаа үйл ажиллагааг;

- 1.3.5 “терроризмыг санхүүжүүлэх” гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг;
- 1.3.6 “гүйлгээ” гэж хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, бэлэн мөнгө, үнэт цаас, зээл, өр болон санхүүгийн бусад хэрэгслийг бусдад шилжүүлэх, хүлээн авах, худалдах, худалдан авах, зээлийг эргэн төлөх, дүрмийн санд хөрөнгө оруулах, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, хадгаламжийн болон харилцах данс нээлгэх, дансандаа бэлэн мөнгө хийх, даатгалын хураамж төлөх, даатгалын нөхөн олговор олгох, давхар даатгалын хураамж төлөх, валют худалдах болон худалдан авах зэрэг мэдээлэх үүрэгтэй этгээдийн Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн үйлчилгээг;
- 1.3.7 “сэжигтэй гүйлгээ” гэж мөнгөний гарал үүсэл, эцсийн хүлээн авагч нь тодорхой бус, эсхүл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хяналтыг механизм бүрдүүлээгүй улсаар дамжуулан хийсэн, түүнчлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзэж байгаа гүйлгээг;
- 1.3.8 “бэлэн мөнгөний гүйлгээ” гэж үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглан хийсэн гүйлгээг;
- 1.3.9 “бэлэн бус мөнгөний гүйлгээ” гэж олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, инкасс, чек, вексель, төлбөрийн карт, электрон төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр хийсэн гүйлгээг;
- 1.3.10 “гүйлгээг түдгэлзүүлэх” гэж сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг шалгах зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан шийдвэрийн дагуу тухайн гүйлгээг түр зогсоохыг;
- 1.3.11 “харилцагч” гэж хуулиар олгосон төрөл бүрийн үйлчилгээг авч байгаа хувь хүн болон, хуулийн этгээдийг;
- 1.3.12 “харилцагчийн тухай албан ёсны бичиг баримт” гэж тухайн харилцагч хувь хүний овог, нэр, төрсөн огноо, аж ахуйн нэгжийн хувьд байгуулагдсан огноо, гэрчилгээ болон бусад баримтын дугаар бүхий төрийн байгууллагаас олгосон хугацаа нь хүчинтэй бичиг баримт (иргэний үнэмлэх, гадаад паспорт, аж ахуйн нэгжийн бүртгэлийн гэрчилгээ)-ын эх хувийг;
- 1.3.13 “харилцагчийн талаарх мэдээллийг шалгах” гэж харилцагчийг таньж мэдэх, харилцагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэх, зорилгоор харилцагчийн албан ёсны бичиг баримт (иргэний үнэмлэх, гадаад паспорт)-ыг үзэхийг;
- 1.3.14 “бэлэн мөнгөний гүйлгээний тайлан” гэж мөнгөний гүйлгээний тухай мэдээллийг агуулсан Монголбанкнаас баталсан маягтын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлэх бичиг баримтыг;

- 1.3.15 “сэжигтэй гүйлгээний тайлан” гэж сэжигтэй гүйлгээ, түүнийг хийж гүйцэтгэсэн этгээдийн тухай мэдээллийг агуулсан Монголбанкнаас баталсан маягтын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлэх бичиг баримтыг;
- 1.3.16 “улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг;
- 1.3.17 “эцсийн өмчлөгч” гэж
- а. харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
 - б. харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
 - с. хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
- 1.3.18 “хяналтын дүн” гэж 20 сая төгрөг түүнтэй тэнцэх хэмжээний дүнг;
- 1.3.19 “хориг арга хэмжээний жагсаалт” гэж Нэгдсэн Үндэсний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан тогтоолын дагуу үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой баталсан хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг;

ХОЁР. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ

- 2.1 МҮЭ нь харилцагчийг таньж мэдэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөгдсөн үйлчилгээ үзүүлэхийн өмнө дараах мэдээллийг харилцагчаас гаргуулж авна.
- 2.1.1 Харилцагч нь иргэн бол түүний иргэний үнэмлэх, гадаадын иргэн бол гадаад паспортын хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, эцэг (эх)-ийн нэр өөрийн нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар;
- 2.1.2 Харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, албан ёсны хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж,

- хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, харилцах утасны дугаар, төлөөлөн үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээдийн нэр, хаяг;
- 2.2 МҮЭ нь 20 сая төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют буюу түүнээс дээш дүнтэй тэнцэх гадаад валютын зээлийн гүйлгээ хийхийн өмнө харилцагчаар энэ журмын 2.1-д заасан мэдээллийг гаргуулж авна.
- 2.3 МҮЭ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1-д заасны дагуу дараах тохиолдолд харилцагчийн талаарх өмнө нь авсан мэдээллийг шалгах үүрэгтэй. Үүнд:
- 2.3.1 Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөгдсөн 20 сая төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют буюу түүнээс дээш дүнтэй тэнцэх гадаад валютын зээлийн гүйлгээ хийж санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийн өмнө;
- 2.3.2 Хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь 20 сая төгрөгөөс бага боловч нийт үнийн дүн нь 20 сая төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют буюу түүнээс дээш үнийн дүнтэй бөгөөд энэхүү гүйлгээ нь энэ журмын 2.2-т заасан мэдээллийг гаргаж өгөхөөс зайлсхийх зорилго агуулсан гэж үзэх үндэслэл байгаа бол;
- 2.3.3 Харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах шаардлагатай бол;
- 2.3.4 Тухайн харилцагчийг буюу гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж үзэх бусад үндэслэл байгаа бол;
- 2.4 Харилцагчийн МҮЭ-д өгсөн мэдээлэл буруу, ташаа болох нь тогтоогдвол, МҮЭ нь харилцагчаас энэ тухай тайлбар гаргуулах бөгөөд тайлбар өгөхөөс татгалзах, мэдээлэл нь хуурамч, үндэслэлгүй бол харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзана.
- 2.5 Харилцагч энэ журмын 2.2-т заасан мэдээллийг өгөхөөс татгалзвал зээл олгох, гүйлгээ хийх, өөрийн үнэт цаасыг төлбөрийн баталгаа болгож урьдчилгаа авах болон санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй.

ГУРАВ. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ НАРИЙВЧИЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1 МҮЭ нь эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн хэсэгт харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг нарийвчлан хийнэ.
- 3.2 МҮЭ нь дараах тохиолдлыг өндөр эрсдэлтэйд авч үзнэ:
- 3.2.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.9 дугаар зүйлд заасан харилцагчийг;
- 3.2.2 Тус журмын 4.1 дүгээр зүйлд заасан гүйлгээ хийх тохиолдолд;
- 3.2.3 Цахим шилжүүлэг, корреспондент харилцаанд үндэслэн хийгдэж байгаа гүйлгээ болон улс төрд нөлөө бүхий этгээд гэдэг ангилалд хамаарах харилцагчийн эсхүл харилцагчийн эцсийн өмчлөгч нь улс төрд нөлөө бүхий этгээд байгаа тохиолдолд;
- 3.2.4 Эрх бүхий хяналт, зохицуулалтын байгууллага, Санхүү мэдээллийн албанаас эсхүл Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага

- /ФАТФ/, ФАТФ-ын бүс нутгийн байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдсон улс орон, бүс нутагтай холбоотой гүйлгээ;
- 3.2.5 Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг гуравдагч этгээдээр дамжуулан хийсэн эсхүл зайнаас бизнесийн харилцаа үүсгэсэн харилцагчийн гүйлгээг.
- 3.3 Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авна. Үүнд:
- 3.3.1 Тухайн харилцагчийн эрхэлж буй ажил, бизнес, хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний зориулалт, утга зэрэгтэй холбоотой нэмэлт мэдээллийг гаргуулж авах, боломжийн хэмжээнд эдгээр мэдээллийн үнэн бодит байдлыг нягтлах;
- 3.3.2 Тухайн харилцагчтай бизнесийн харилцааг цаашид үргэлжлүүлэх эсэх талаар Гүйцэтгэх удирдлагын зөвшөөрлийг авна; Энэ зөвшөөрөл нь харилцагчийг хүлээн зөвшөөрөх дотоод журмын хүрээнд явагдах бөгөөд энэ журамд мэдээлэх үүрэгтэй этгээдийн хүлээн зөвшөөрөх хэмжээнээс хэт өндөр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл бүхий харилцагч болон үнэн зөв мэдээллийг өгөхөөс зайлсхийсэн харилцагчтай бизнесийн харилцаа үүсгэхээс татгалзах боломжтой зохицуулалтыг оруулсан байх шаардлагатай;
- 3.3.3 Харилцагчийн данс, гүйлгээнд тавих хяналт давтамжийг нэмэгдүүлэх, хяналтын цар хүрээг өргөжүүлэн харилцаж байгаа бусад этгээдийг хяналтад хамруулах, харилцагчийг таньж мэдэх зорилгоор харилцагчаас гаргуулан авах мэдээллийг эргэж хянах;
- 3.3.4 Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагаатай холбоотой бусад журам, зааврын шаардлагууд.
- 3.4 Харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг өндөр эрсдэлтэй харилцагчид бүтээгдэхүүн, үйлчилгээ авах бүрт нь холбогдох нэмэлт мэдээллийг авах, өмнө нь өгсөн мэдээлэлд гарсан өөрчлөлтийг тусгах замаар байнгын үргэлжлэх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ТУСГАЙЛАН ХЯНАЛТ ТАВИХ

- 4.1 МҮЭ нь дараах гүйлгээнд тусгайлсан хяналт тавих үүрэгтэй. Үүнд:
- а. Огцом өөрчлөгдсөн их дүнтэй;
 - б. Эдийн засаг хууль зүйн илт үндэслэлгүй;
 - в. Улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн;
 - г. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсаар дамжуулан хийгдсэн.
- 4.2 МҮЭ нь 4.1-д заасан гүйлгээний талаар нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах, гүйлгээ, бизнесийн харилцааны зорилго, мөн чанарын боломжийн хүрээнд шалгаж, үр дүнг бичгээр хадгална.

ТАВ.ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ ТОГТООХ

- 5.1 Эцсийн өмчлөгчийг дараах шалтгаанаар шалгаж тогтооно.
- 5.1.1 Хувьцааны дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг;
- 5.1.2 5.1.1-т заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж байгаа, эсхүл өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүнийг;
- 5.1.3 5.1.1, 5.1.2-т заасан хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг.

**ЗУРГАА. НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙН ЗӨВЛӨЛ
БОЛОН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС ГАРГАСАН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ**

- 6.1 МҮЭ нь Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.17, 3.1.18-д заасан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдэлд үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
- 6.2 МҮЭ нь хориг арга хэмжээний жагсаалтад хамаарах хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн нэр илэрсэн, мэдсэн даруйд урьдчилан мэдэгдэлгүйгээр холбогдох данс, хөрөнгийн хөдөлгөөнийг шууд зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх эрхгүй болгож, энэ тухай тагнуулын байгууллага, Санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдээлнэ.
- 6.3 МҮЭ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улс орон, нутаг дэвсгэрийн харилцагч нарт харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх ба шаардлагатай бол хууль, хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасан арга хэмжээг авна.
- 6.4 МҮЭ нь 6.2-т заасан мэдээллийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23.2, 23.6-д заасан журмын дагуу мэдээлнэ.
- 6.5 МҮН нь Жагсаалтаар хориглогдсон хүн, хуулийн этгээдийн мэдээллийг сар тутам Даатгалын програмын хар жагсаалтанд оруулж байна.

ДОЛОО. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХ

- 7.1 МҮЭ нь гүйлгээг мөнгө угаах, эсхүл терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж үзэх хангалттай үндэслэл байгаа бол эсхүл хууль тогтоомжид хориглоогүй мэдээлэл өгөхөөс илт татгалзсан харилцагчийн тухай сэжигтэй гүйлгээний тайланг бөглөж 24 цагийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.
- 7.2 МҮЭ-ийн хэрэгжилт хариуцсан ажилтан нь тодорхой нэг гүйлгээ, харилцагчийн талаарх Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагуудад мэдээлэл өгснийг байгууллагын болон мэргэжлийн нууц задруулсан гэж үзэх үндэслэл болохгүй.

- 7.3 МҮЭ нь сэжигтэй гүйлгээний тайлан, тэдгээрийн талаарх мэдээллийг өгсөн ажилтны нууцлал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллана.
- 7.4 МҮЭ-ийн удирдлага, ажилтан нь сэжигтэй гүйлгээний тайланг Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлсэн талаар харилцагчдад ямар нэг байдлаар мэдэгдэхийг хориглоно.
- 7.5 МҮЭ нь дараах гүйлгээг бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн дагуу ажлын 7 өдрийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлнэ.
- 7.5.1 20 сая төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют буюу түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ;
- 7.5.2 Ажлын нэг өдрийн дотор хийсэн хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн бэлэн мөнгөний гүйлгээний дүн 20 сая төгрөгөөс бага боловч, нийт үнийн дүн нь 20 сая төгрөг болон түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют буюу түүнээс дээш дүнтэй гүйлгээг бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

НАЙМ. ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ ЗОГСООХ БОЛОН ХОРИГЛОХ

- 8.1 МҮЭ нь хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогын хөдөлгөөнийг тухайн этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр нэн даруй зогсоож, тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдэгдэнэ.
- 8.2 МҮЭ нь хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, түүнтэй холбоотой, эсхүл түүнийг төлөөлж байгаа этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
- 8.3 МҮЭ-ээс энэ журмын 8.1, 8.2-т заасан үүргээ хэрэгжүүлэхдээ дор дурдсан хөрөнгийг адилтган үзэж, хөдөлгөөнийг зогсооно:
- 8.3.1 Зөвхөн тодорхой террорист үйлдэл, хуйвалдаан, заналхийлэлд хамаарах бус, жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүх мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;
- 8.3.2 Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдээс бүхэлд нь буюу хэсэгчлэн, дангаараа буюу хамтран, шууд буюу шууд бусаар эзэмшдэг буюу хяналтаа тогтоосон бүх мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө;
- 8.3.3 Энэ журмын 8.3.1, 8.3.2-т заасан хөрөнгөөс бий болсон мөнгөн хуримтлал, бусад хөрөнгө, мөн жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн заавраар, тэдгээрийн өмнөөс үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийн мөнгөн хуримтлал буюу бусад хөрөнгө;
- 8.3.4 НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн холбогдох тогтоолоор жагсаалтад оруулсан усан тээврийн хэрэгсэл.
- 8.4 Хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоосон хүн, хуулийн этгээдийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой төлбөр, хүүгийн болон бусад төлбөрийг мөн адил зогсооно.

- 8.5 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.3-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээд энэ журмын дагуу хөрөнгийн хөдөлгөөнийг зогсоох, түүнтэй холбогдсон бусад арга хэмжээ авсан бол энэ талаар тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албанд энэ журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлалд заасан маягтын дагуу мэдээлнэ.
- 8.6 МҮЭ нь энэ журмын 8.5-д заасны дагуу тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албаны шаардсан нэмэлт мэдээллийг даруй гаргаж өгөх үүрэгтэй.

ЕС. СЭЖИГТЭЙ БОЛОН БЭЛЭН МӨНГӨНИЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ МЭДЭЭЛЭХ АРГА ХЭЛБЭР

- 9.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг факс, цахим хэлбэрээр эсхүл бичгээр нууцлал, аюулгүй байдлыг хангаж Санхүүгийн мэдээллийн албанд дараахь байдлаар мэдээлнэ.
- 9.1.1 Сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг цахим хэлбэрээр ирүүлбэл, мэдээллийн төрөл, ангилал, арга хэлбэрийг урьдчилж мэдэгдэх;
- 9.1.2 Сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг бичгээр ирүүлбэл, гарын үсгээр баталгаажуулж, тэдгээрийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцах.
- 9.1.3. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 11.1-д заасны дагуу харилцагчийн хийсэн буюу хийлгүүлэх гэж байгаа гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэлтэй гэж үзвэл Санхүүгийн мэдээллийн албанд тухайн гүйлгээг түдгэлзүүлэх шийдвэр гаргаж мэдээлэх үүрэгтэй этгээдэд бичгээр, тийм боломжгүй бол утсаар 24 цагийн дотор мэдэгдэх бөгөөд хэрэв утсаар мэдэгдсэн бол түүнийгээ нэн даруй факс буюу бичгээр баталгаажуулна. Гүйлгээг түдгэлзүүлэх хугацаа ажлын 3 өдрөөс хэтрэхгүй байна.
- 9.2 Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, тогтоомжийн дагуу сэжигтэй гүйлгээний тайлан, бэлэн мөнгөний гүйлгээний тайланд дурдсан мэдээллийг хуулийн байгууллагаар шалгуулах шаардлагатай гэж үзвэл, холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэх ба Санхүүгийн мэдээллийн албанд нэг хувийг хүргүүлнэ.

АРАВ. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, ТҮҮНИЙ АРГАЧЛАЛ

- 10.1 МҮЭ нь учирч болох эрсдэлийг ойлгож үр дүнтэй удирдах зорилгоор эрсдэлийг үнэлэх ажиллагааг улирал бүрт хийж байна. Эрсдэлийг үнэлэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:
- 10.1.1 Харилцагчийн эрсдэл
- 10.1.2 Бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл

- 10.1.3 Газар зүйн байршил бүс нутгийн эрсдэл /тухайн харилцагчийн үйл ажиллагаа явуулж байгаа эсвэл гүйлгээг шилжүүлж байгаа болон хүлээн авч байгаа улс орон, бүс нутаг/
- 10.1.4 Бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчид хүргэх арга хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл
- 10.1.5 Дансны төрөл эсвэл бизнесийн харилцааны зорилгоос үүсэх эрсдэл
- 10.1.6 Гүйлгээтэй холбоотой эрсдэл
- 10.2 МҮЭ нь 10.1-д заасан хүчин зүйлсийг бага, дунд, өндөр, маш өндөр гэсэн эрсдэлийн түвшинд хувааж түвшин бүрийн нөлөө болон таамаглалыг дүгнэн эрсдэлийн матриц байгуулан эрсдэлийг үнэлнэ.
- 10.3 Эрсдэлийн үнэлгээ болон түүнд ашигласан мэдээллийг баримтжуулан тухай бүр шинэчлэн хадгалах бөгөөд хянан шалгагч шаардсан үед гаргаж өгөхөд бэлэн байлгана.
- 10.4 МҮЭ нь өөрт учирч болох мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний үр дүнд тулгуурлан тухайн эрсдэлийг удирдах, бууруулахад чиглэсэн оновчтой арга хэмжээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын хөтөлбөр, бодлого, журамд тусгана. Өндөр эрсдэлтэй тохиолдолд эрсдэлийг удирдах болон бууруулах нэмэлт арга хэмжээг авна.

АРВАН НЭГ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛТНЫГ ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ, ТҮҮНИЙ ЭРХ ҮҮРЭГ

- 11.1 Эрсдэлийн хяналт тавих үүрэг бүхий Дотоод хяналт нийцүүлэлтийн хороо, Эрсдэлийн Хороо байгуулан ажиллах.
- 11.2 Өдөр тутмын үүрэг хэрэгжүүлэх хяналт тавих ажилтныг томилон түүний эрх үүргийг хэрэгжүүлэх боломж, аюулгүй байдал, программ хангамж зэрэг ажиллах боломжоор хангана.
- 11.3 Хяналт хэрэгжүүлэх ажилтан нь тухайн компанийн мэргэжил, туршлагатай ажилтан байх бөгөөд үндсэн ажлаас гадуур хавсарч гүйцэтгэнэ.
- 11.4 Хяналт тавих ажилтан нь дараах үүрэгтэй; Үүнд:
 - 11.4.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан дотоод хяналтын хөтөлбөрөө гаргаж түүнийг өөрийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд тохирч байгаа эсэхийг байнга үнэлж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, түүнийг хүргэх хэлбэр, газар зүйн байршил болон харилцагчийн төрлөөс хамаарах эрсдэлийг удирдахад тохируулан шинэчилж байна.
 - 11.4.2 Дотоод хяналтын хөтөлбөрийг Компанийн бүх салбар нэгж, ажиллагсад хэрэгжүүлж энэхүү журам болон бусад холбогдох хууль тогтоомжтой танилцаж өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах удирдамж зааварчилгаагаар хангаж ажиллана;
 - 11.4.3 Хяналт хэрэгжүүлэх ажилтан нь сэжигтэй гүйлгээний төрлүүд, тэдгээрийг илрүүлэх арга, хэлбэр, сэжигтэй гүйлгээний тайланг бөглөх, мэдээлэх,

- дамжуулах талаар Компанийн удирдлага, ажилтнуудад жилд нэгээс доошгүй удаа сургалт зохион байгуулах;
- 11.4.4 Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэхээс бусад тохиолдолд харилцагчийн мэдээллийг бусдад мэдээлэх, санхүүгийн албанд хүргүүлсэн мэдээллийг харилцагчид мэдээлэхийг хориглоно.
- 11.4.5 НҮБ-ийн Аюулгүйн зөвлөлөөс гаргасан хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн жагсаалт, мөн улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн, өндөр эрсдэлтэй харилцагч, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж эрх бүхий байгууллагаас тогтоосон улс гэж зарласан этгээдийн жагсаалтыг тухай бүр шинэчилэх, жагсаалтыг өдөр тутам үйл ажиллагаанд ашиглах, мөн тухай бүр харилцагчдад хяналт тавьж ажиллах.
- 11.4.6 “НҮБ-ын тогтоолоор террорист гэж зарлагдсан байгууллага, этгээдийн нэрсийн жагсаалтыг гаргах, мэдээлэх, тэдгээрийн гүйлгээг түдгэлзүүлэх тухай журам”-ын дагуу уг жагсаалтад нэр нь орсон этгээдэд үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллахыг хориглоно. Хэрэв жагсаалтад дурдагдсан этгээд болох нь тогтоогдвол Санхүүгийн мэдээллийн албанд 24 цагийн дотор мэдэгдэнэ.
- 11.4.7 Хяналт хэрэгжүүлэх ажилтан нь компанийн програм хангамжид “сэжигтэй гүйлгээ” байж магадгүй тухай мэдээлдэг байхаар хөгжүүлэлтийг хийх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ.
- 11.5 МҮЭ-ийн хяналт тавих ажилтан нь дараах эрхтэй
- 11.5.1 Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох журамд заасан эрхийг эдэлнэ.
- 11.5.2 Компаниас ажлын ачаалал зэргийн харгалзан үзэж шаардлагатай тохиолдолд нэмэлт хангамж, урамшуулал тооцуулан авах;

АРВАН ХОЁР. ХАРИУЦЛАГА

- 12.1 Энэхүү журмыг зөрчсөн салбар нэгж, ажиллагсдад Компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

***** МИГ ДААТГАЛ ХХК *****